МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.10.21 № 71

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Т.АУБАКИР ТАНАА

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, нийгмийн хамгааллын асуудлаар

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, нийгмийн хамгаалал, бие даан амьдрах, хөдөлмөр эрхлэх боломжийг хангахтай холбоотой хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, хүрсэн үр дүн болон цаашид авах арга хэмжээг тодруулах зорилгоор дараах асуулгыг тавьж байна. Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дараах асуулгыг тавьж байна.

Асуудал тус бүрээр хэрэгжилт, хүрсэн үр дүн, хэрэгжилт хангалтгүй байгаа бол түүний шалтгаан, арилгах арга хэмжээ, хариуцах байгууллага, хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах санхүүжилт, эх үүсвэрийг холбогдох судалгаа, тоон мэдээллийн хамт төсөв, санхүүжилтийн мэдээллийг 2026 оны батлагдсан төсөв, гүйцэтгэл болон 2027 оны төсвийн төсөлд тусгасан дүнгээр харьцуулан, хамрагдалтын мэдээллийг боломжтой хүрээнд насны бүлэг, хүйс, аймаг, нийслэлээр ангилан ирүүлнэ үү.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.25-д “Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг үе шаттайгаар нэвтрүүлж, салбар дундын нийгмийн үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангана” гэж заасан. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд миний бие олон улсын байгууллага, холбогдох яамтай хамтран хэд хэдэн арга хэмжээ зохион байгуулж, ICF-ыг нэвтрүүлэх замын зураглал боловсруулсан. Уг замын зураглалыг хэрэгжүүлэх салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах ажлыг манлайлан зохион байгуулахаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд 2025 оны 12 дугаар сарын уулзалтын үеэр илэрхийлсэн.

1.Төлөвлөгөө боловсруулах ажлын явц, холбогдох яам, байгууллагын оролцоо, хариуцах байгууллага, санхүүжилтийн тооцоо болон Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх хугацааны талаарх тайлбар; төлөвлөгөө боловсруулж, хэлэлцүүлэх ажил удааширсан бол түүний шалтгаан, цаашид авах арга хэмжээ;

2.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд нийгмийн хамгаалал, хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээ хүргэх зохицуулалтын хэрэгжилт, үйлчилгээний төрөл, хамрагдалт, санхүүжилт, хүрсэн үр дүнгийн талаар; хүүхдийн бодит хэрэгцээ, шаардлагатай дэмжлэгийн түвшнийг хэрхэн тодорхойлж байгаа, хангагдаагүй хэрэгцээ болон түүнийг шийдвэрлэх арга хэмжээний талаар;

2026000209

3.ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр хийсэн туслах технологийн хэрэгцээний үндэсний судалгаагаар туслах бүтээгдэхүүн шаардлагатай боловч хэрэгцээ нь хангагдаагүй хүн амын асуудлыг тодорхойлсон. Иймд судалгааны үр дүнг бодлого, үйлчилгээ, төсвийн төлөвлөлтөд хэрхэн ашигласан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ахмад настанд олгож буй туслах бүтээгдэхүүний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хэрэгжилт, үр дүн;

4.Туслах технологийн үндэсний стратеги боловсруулах, үндэсний төв байгуулах асуудлаар яам ямар бодлого, байр суурь баримталж байгаа, хэрэгцээ, үндэслэл, өртөг, санхүүжилт, хүний нөөцийн тооцоо хийсэн эсэх болон шийдвэрлэх төлөвлөгөө, хугацааны талаарх мэдээлэл;

5.Эрт илрүүлэх үзлэгээр оношлогдсон, эмнэлзүйн үнэлгээгээр шаардлагатай нь тогтоогдсон хүүхдэд улавч, нурууны бэхэлгээ болон бусад туслах бүтээгдэхүүнийг цаг алдалгүй хүргэхэд үйлчилгээний хүчин чадал, санхүүжилт, хүний нөөц бэлэн байгаа эсэх; бүтээгдэхүүнийг үнэлэх, сонгох, тохируулах, хэрэглэгчийг сургах, засварлах үйлчилгээг Эрүүл мэндийн яамтай хэрхэн уялдуулах, шаардлагатай мэргэжилтнийг бэлтгэх төлөвлөгөөний талаар;

6.Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах, боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх, нийгмийн амьдралд оролцох боломжийг нэмэгдүүлэх үйлчилгээний хэрэгжилт, санхүүжилт, хэрэгцээ, хамрагдалт, үр дүнгийн талаар; мөнгөн тэтгэмж давамгайлсан тогтолцоонд үйлчилгээний санхүүжилтийг үе шаттай нэмэгдүүлэх талаар баримталж буй бодлого, төлөвлөгөө, хэрэгжилтийн хүндрэл болон 2027 оны төсвийн төсөлд тусгасан арга хэмжээний талаар;

7.Хөгжлийн бэрхшээлтэй хүний гэр бүл, асран хамгаалагчаас хэт хамааралтай байдлыг бууруулах хувийн туслах болон олон нийтэд түшиглэсэн үйлчилгээний эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт, хамрагдалт, хэрэгцээ, өртгийн тооцоо болон тогтвортой санхүүжилт, үйлчилгээ үзүүлэгчийн шалгуур, чанарын хяналтыг бүрдүүлэхэд тулгамдаж буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээ, хугацаа;

8.Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэргэжлийн чиг баримжаа, сургалт, ажлын байрны тохируулга, ажилд зуучлах болон ажлын байранд тогтвортой ажиллах дэмжлэгийн хэрэгжилт, санхүүжилт, хүрсэн үр дүн, эдгээрийг нэг багц үйлчилгээ болгон хүргэх талаар баримталж буй бодлого, шаардагдах санхүүжилт, хэрэгжүүлэх төлөвлөгөө болон ажилд орсон, ажлын байрандаа тогтвортой ажиллаж буй хүний тоо, үр дүнг үнэлэх аргачлал;

9.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд чиглэсэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, санхүүжилт, хамрагдалт, үр дүн болон хүсэлт гаргасан боловч дэмжлэг авч чадаагүй хүний тоо, шалтгаан болон дэмжлэгийг зөвхөн жилд нэг удаа бус хэрэгцээнд нийцүүлэн үе шаттай, тогтмол авах боломжийг хэрхэн судалсан, энэ чиглэлээр гаргасан шийдвэр, төлөвлөсөн зохицуулалт, санхүүжилтийн талаар;

10.Олдмол хөгжлийн бэрхшээлтэй болсон хүний эмчилгээ, сэргээн засалтаас мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтэд шилжих үйлчилгээг Эрүүл мэндийн яам болон холбогдох байгууллагатай хэрхэн уялдуулж, хэрэгжилт, хүрсэн үр дүн, мэргэжлийн нөхөн сэргээлт, давтан сургалт, ажилд зуучлах, ажлын байрны тохируулгын үйлчилгээний хэрэгцээ, хамрагдалт, санхүүжилт, үйлчилгээний тасалдал болон түүнийг шийдвэрлэх арга хэмжээний талаар;

2026009209

11.Байнгын асаргаа шаардлагатай иргэн болон түүнийг асарч буй иргэдийн халамжийн тэтгэмж, дэмжлэгийг зогсоосон, эсхүл үргэлжлүүлэн олгохоос татгалзсан шийдвэрийн эрх зүйн үндэслэл, хэрэглэж буй шалгуур, үнэлгээний аргачлал, уг шийдвэрт хамрагдсан иргэдийн тоо, шалтгаан;

12.Эдгээр шийдвэр иргэний асаргааны бодит хэрэгцээнд нийцэж байгаа эсэхийг хэрхэн хянасан, гомдол, дахин үнэлгээний хүсэлтийг шийдвэрлэсэн үр дүн болон үндэслэлгүйгээр хасагдсан нь тогтоогдсон иргэдийн эрхийг сэргээх, шаардлагатай дэмжлэгийг тасралтгүй хүргэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар;

13.Албан ёсны бүртгэлд хамрагдаагүй, шаардлагатай үйлчилгээ авч чадахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг илрүүлэх, хэрэгцээг нь тодорхойлох ажлын хэрэгжилт, судалгааны үр дүн, хүүхдийг 0-2, 3-5, 6-18 насны үе шатаар мэдээллийг бүрдүүлж, шаардлагатай дэмжлэгийг тодорхойлох тогтолцоо, мэдээллийн зөрүү, давхардал, орхигдлыг бууруулах арга хэмжээний талаарх тайлбар болон судалгаа, статистикийн үр дүнг 2027 оны төсвийн төлөвлөлтөд ашигласан аргачлал, хэрэгцээ, санхүүжилтийн тооцоо.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН О.САРАНЧУЛУУН

2026009209